



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 713

Улаанбаатар хот

“Өгийнмандал” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 245 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 7.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өгийнмандал” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэл сунгасугай.

2. Цаашид тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлтийг хууль тогтоомжид заасан хугацаанд ирүүлэх, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Өгийнмандал” ХЗХ (Т.Ариунболд)-нд анхааруулсугай.

3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтад холбогдох тэмдэглэгээг 21 хоногийн дотор хийлгэхийг “Өгийнмандал” ХЗХ (Т.Ариунболд)-нд үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН

1518001546